



**МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

**Хуралдааныг цахимаар  
зохион байгуулах тухай**

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

2. Цахим хуралдааны бэлтгэлийг хангаж ажиллахыг Нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/-д даалгасугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000027